



БАЯНТАЛ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

МЭДЭЭЛЭЛ

2023.09.29-2023.10.13

<http://bayantal.gs.gov.mn/>

ᠪᠠᠶ᠋ᠠᠨᠲᠠᠯᠤ ᠰᠤᠮᠤ ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ ᠲᠠᠮᠭᠢᠨ ᠭᠠᠰᠠᠷ

Удирдлага зохион байгуулалт

- Дотоод ажил

Засаг дарга , Засаг даргын Тамгын газарт ирсэн, явсан, хариутай албан бичиг, өргөдөл гомдолын шийдвэрлэлтийн талаар:

- **1. Ирсэн албан бичиг -10**
- -Үүнээс: Бүртгэл хяналтын карт хөтөлсөн хариутай албан бичиг -3
- Хугацаандаа явсан хариутай албан бичиг -2
- Хугацаа хоцорсон -0
- Хугацаа болоогүй-1
- **2. Явуулсан албан бичиг-15**
- **3. Өргөдөл, гомдолын шийдвэрлэлт**
- **1. Засаг даргад ирсэн өргөдөл-1**


Удирдлага зохион байгуулалт

- Сумын хэмжээнд хугацаат цэргийн албаны цэрэг татлага 2023 оны 10 дугаар сарын 12-ний өдөр Засаг даргын Тамгын газрын байранд зохион цэргийн байгуулагдлаа.
- Цэрэг татлагаар 18-25 насны, өөр аймаг орон нутагт амьдарч байгаагаас үл хамааран нийт 47 иргэн хамрагдах ёстойгоос 27 иргэн хамрагдаж 6 иргэн тэнцсэн.



Орон нутгийн хөгжлийн сангийн мэдээ мэдээлэл

- 2023 оны 08-р сарын 23-ны өдрийн сумын ИТХ-ын 6 дугаар тогтоолоор 28 төсөл хөтөлбөр арга хэмжээг Орон нутгийн хөгжлийн сангийн харөнгөөр хийж хэрэгжүүлэхээр баталсан. Худалдан авах журмын хүрээнд:
 - Шууд худалдан авалтын 12 арга хэмжээ амжилттай хэрэгжиж дууссан.
 - Харьцуулалтын аргаар 3 ажил төлөвлөгдсөнөөс 2 ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан.
 - “Шинээр худаг гаргах” 30 сая төгрөгийн тендер 2023 оны 10 дугаар сарын 06-ны өдөр зарлагдсан.
- ОНХС-гийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн явц 42,8 хувьтай явагдаж байна.
- - 2022 он, 2023 оны 9-р сар хүртэлх ОНХС-гийн үйл ажиллагаанд санхүүгийн дотоод аудит-аас гүйцэтгэлийн хяналт шалгалтад хийгдэж байна.
- -2023 оны 10 дугаар сарын 05-ны өдөр дотоод хяналт, шилэн дансны тухай сургалтад сумын төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний байгууллагын 9 албан хаагч хамрагдсан байна..



Нийгмийн бодлогын хүрээнд:

Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлөөс зохион байгуулсан сумдын хамтарсан багийг чадавхжуулах 2 өдрийн сургалтад 5 албан хаагч хамрагдсан.


Сумын амьжиргаа дэмжих орон тооны бус зөвлөл 2023 оны 08 дугаар сарын 23 ны өдөр Шинэчлэгдсэн Байгуулагдсан. Тус зөвлөл нь анхдугаар хуралдаан 2023 оны 10 дугаар сарын 06-ны өдөр болсон. Хуралдаанаар 5 асуудлыг хэлэлцэж 100 хувь шийдвэрлэсэн.

Олон улсын охидын эрхийг хамгаалах өдөрт зориулсан **"Сонсьё, дэмжье, хамгаалъя"** өдөрлөгийг Говьсүмбэр аймгийн Цагдаагийн хэлтэс, Баянтал сумын ЗДТГ, ЕБСургуультай хамтран ЕБС-н эмэгтэй сурагчдын дунд зохион байгуулсан. Аймгийн цагдаагийн хэлтсээс "Хүүхэд хамгааллын тухай хууль", "Цахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалах нь", "Үе тэнгийн дээрхилт" зэрэг сэдвээр сургалт мэдээлэл хийж бага насны хүүхдийг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх агуулгын хүрээнд зохиогдсон "Улаан гэрэл, улаан бөмбөлөг" дууг сурагчдад зааж сурталчиллаа. Сумын ЗДТГ-аас "Хүчирхэг охид" сэдвээр танилцуулга мэдээлэл хийж 50 зөвлөмж гарын авлага тараасан.



Санхүү төсөв: 2023 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн талаар сургалт зохион байгуулах

Санхүү алба болон Санхүүгийн хяналт, дотоод аудит албатай хамтран 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдөр Засаг дарга, санхүү албаны дарга, төсвийн байгууллагын нягтлан бодогч, байгууллагын дарга нарыг хамруулан Дотоод хяналт болон Шилэн дансны хуулийн хэрэгжилт, шилэн дансны цахим сайтад гарч буй алдааны талаар сургалт зохион байгууллан, харилцан ярилцаж, шилэн дансны мэдээллээ үнэн зөв оруулах, хугацаа хоцроохгүй байх талаар арга зүйн зөвлөгөө, зааварчилгаа авч ажиллаа.




Санхүү төсөв: 8 сарын орлогын бүрдүүлэлтийн талаар

2023 оны 09 дүгээр сарын 30-ны байдлаар 123,010.3 мянган төгрөг төлөвлөгөө батлагдсанаас гүйцэтгэлээр 150,453.4 мянган төгрөг буюу 122.3 хувиар орлогыг давуулан биелүүлсэн байна.

Баянтал сумын нэгтгэлийн/ОН/ төлөвлөгөө 1,362,786.5 мянган төгрөг, гүйцэтгэл 1,020,243.3 мянган төгрөг байна. Үүнээс үндсэн цалин,унаа хоол,нэмэгдэл урамшуулалд 303,056.9 мянган төгрөг НДШ 38,707.9 мянган төгрөг зарцуулсан байна.

Баянтал сумын нэгтгэлийн /ОН/ өглөг 6,500.0 мянган төгрөг , авлага 13,258.5 мянган төгрөг байна.

2023 оны 9 сарын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл



Санхүү төсөв

- ГСА дахь Төрийн аудитын газраас 2022 оны Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсхэрэгжилтийг шалгасан
- Багш ажилчдын нэгдсэн хурлыг зохион байгуулж , “Боловсролын багц хууль” ийн мэддлэг олгох сургалт
- Монголын багш нарын баяыг угтан зохион байгуулагдсан спортын арга хэмжээнд 12 багш 11 ажилчид гар бөмбөг, сагсан бөмбөгийн төрөлд амжилттай оролцсон.



Говьсүмбэр аймгийн Баянтал сумын Ерөнхий боловсролын сургууль

2023 оны 09 дугаар сарын 28-ны өдөр ГСА-ийн ГБХЗХГ-аас зохион байгуулсан гар зураг, зохион бичлэгийн уралдаанд 4а ангийн сурагч Г.Гоо-Үжин тэргүүн байр, 4а ангийн сурагч Н.Маралжингоо тусгай байр, 9а ангийн сурагч Г.Сарануяа эссэ бичлэгийн төрөлд тусгай байр эзэлсэн

09 дугаар сарын 28-29-ний өдрүүдэд ГСА-ийн ГХУССЗ зохион байгуулсан Хамтаран багийг чадавхжуулах сургалтад нийгмийн ажилтан Б.Соёлоо хамрагдсан

09 дүгээр сарын 30-ны өдөр ГСА-ийн БТС хорооноос зохион байгуулагдсан хүүхдийн спортын “Бага олимп” наадамд:

Бөөрөнцөг түлхэлт төрөлд 9а ангийн сурагч М. Анхбаяр хүрэл медаль

Чөлөөт бөх төрөлд 8а ангийн сурагч Б.Номин-Эрдэнэ, 9а ангийн сурагч Э.Баярцэцэг, ба ангийн сурагч Б.Сэрчмаа нар хүрэл медаль



Нийгмийн бодлого – Эрүүл мэнд тусламж үйлчилгээний хүрээнд

Эмчилгээний тоон мэдээлэл

Амбулатори үзлэг- 67 хүн

Эрт илрүүлэг-3 хүн чихрийн

шижин,артерийн гипертенз үзлэг

Яаралтай түргэн тусламж- 19 хүн

Идэвхитэй хяналт- 4 хүн

Өдрийн эмчилгээ- 2 хүн

Хэвтэн эмчлүүлсэн- 13 хүн

Нярайн эргэлт- 1 хүүхэд

10 сараас 8 насны УУ вакцинд хамрагдсан

тоо-0 хүүхэд

Алсын дуудлага- 3 том хүн,хүүхэд-1

Төвийн дуудлага 5 том хүн,хүүхэд-6

Зам тээврийн осол 1



4-р цэцэрлэгийн мэдээ.

- 2023 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр БШУГ-с зохион байгуулсан 1-5 жилийн залуу багш нарын чуулга уулзалтанд манай байгууллагаас 2 багш хамрагдсан. Тус уулзалтаар залуу багш нар Шивээговь сумын уурхайн үйл ажиллагаатай танилцсан. Мөн Чойр уул, Хүүхдийн овоо, Цагаан дарь эх бурхан, Тэмээтэй хөшөө зэрэг Говьсүмбэр аймгийн дурсгалт газруудтай танилцан аяллаа.
- 2023 оны 10 дугаар сарын 04-ны өдөр эцэг эхийн нэг өдрийг тэмдэглэн “Хишиг өдөр” үйл ажиллагааг зохион байгууллаа. Тус үйл ажиллагаанд 3 бүлгийн 5 эцэг эх оролцон хичээл сургалтын үйл ажиллагаатай танилсан.
- 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдөр “Алтан намар” үйл ажиллагааг зохион байгууллаа. Тус үйл ажиллагаанд 3 бүлгийн 75 хүүхэд, 48 эцэг эх оролцон хүүхдүүдэд хүнсний ногоо, жимс жимсгэнийг таниулах хичээл, эцэг эхийн дунд 5 төрөлт тэмцээнийг амжилттай зохион байгуулсан.
- Багш нарын баярыг тохиолдуулан манай байгууллагын ахмад багш Ё.Нансалмаа, дунд бүлгийн багш Б.Золзаяа нар “Говьсүмбэрийн төлөө” медалиар шагнагдлаа.



Байгаль орчин, Хөдөө аж ахуйн бодлого

- **Хөдөө аж ахуйн чиглэлийн үйл ажиллагаа худаг, уст цэг**
- **Намаржилтын ерөнхий нөхцөл байдал:**
 - Энэ намар 88 малчин, 72 мал бүхий өрхийн хонин толгойд шилжүүлснээр 144000 мал намаржиж байна. 2023.10.12-ны байдлаар 0.61 га талбайгаас 4.9 тн төмс, 1.1 га талбайгаас 12.1 тн хүнсний ногоо хураан авч ургац хураалтын явц 88.1 хувьтай байна. Намар цагийн сэрэмжлүүлэг, малчин өрхийн түвшин бэлтгэх өвс тэжээлийн хуваарийг гарган 1-р багийн 12, 2-р багийн 19 малчин өрхөд хүргэж, арга зүйн зөвөлгөө өгсөн. Хоёр малчин Төв, Хэнтий аймагт хадланд гарч одоогийн байдлаар 17 тн байгалийн хадлан бэлтгээд байна. Малчин өрхийн түвшинд 1.7 тн үйлдвэрийн тэжээл худалдан авч нөөцлөөд байна.
- **Малчдад үзүүлж буй нийгэм, эрүүл мэндийн үйлчилгээ:**
 - Эрүүл мэндийн төвөөс 5 малчинд эмнэлгийн үйлчилгээ үзүүлсэн. Малчдад худалдаа, үйлчилгээ, шатах тослох материал зардаг ШТС, эрүүл мэндийн төвийн эмч эмнэлэгийн ажилтнууд тухай бүрд нь үйлчилгээ үзүүлж байна. Мөн эмийн сангийн үйлчилгээ, төрийн E-Монгол хур системийн бүх төрлийн лавлагааны үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна.
- **Малын өвчний байдал, тайван эсэх:**
 - Малын халдварт, паразит өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг Хилийн дэлгэрэх ХХК технологит хугацаанд нь гүйцэтгэж байна. Одоогоор малын өвчлөл гараагүй тайван байна. Малын өвчнөөс сэргийлэх талаар Баянтал ХААТ группэд 2 удаа сэрэмжлүүлэг хүргэсэн. Мал угаалгад 59.0 мян толной мал хамрагдахаас нийт малын 52.5 буюу 31.0 мян толгой мал хамрагдсан дүнтэй байна. Малын халдварт, паразит өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг Хилийн дэлгэрэх ХХК технологит хугацаанд нь гүйцэтгэж байна. Одоогоор малын өвчлөл гараагүй тайван байна. Малын өвчнөөс сэргийлэх талаар Баянтал ХААТ группэд 2 удаа сэрэмжлүүлэг хүргэсэн.



Байгаль орчин, Хөдөө аж ахуйн бодлого

- Төмөр замын 14 болон 16-р зөрлөг дагуух автозамын хогийн цэгийг цэвэрлэсэн /5,5тн/.
- Төвийн 154-р байр, гэр хороололд үүссэн хур хогийг цэвэрлэсэн/1тн/.
- Мод үржүүлгийн талбайд нийт 720 ш хайлаас модны шуудууг ухах ажил явагдаж байна.
- 50 ш улиасны нүхийг ухаж бэлэн болгосон.



Хүнс, жижиг дунд үйлдвэрлэл ,хоршоо хөгжүүлэх сангийн хэрэгжилт

- Орон нутагт ахуй үйлчилгээ эрхлэгч нартай аймгийн Засаг дарга, Сүмбэр сумын Засаг дарга нар уулзалт зохион байгуулж, тулгамдаж буй асуудлыг сонсон, шийдвэрлэх түвшинд ажилласан.
- Баянтал сумаас оёдол эрхэлдэг 2 өндөр настан, тогтмол үйл ажиллагаа явуулдаг оёдолчин Энхтуяа нарын 4 хүн оролцсон. Бид ажлын байран дах цахилгааны нэгдсэн сүлжээг , өрөө тус бүрээр цахилгаан тооцож болох нөхцөлийг бүрдүүлж өгөх хүсэлт тавьсан.
- Хоршоо хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох зарыг энэ онд 2 удаа зарлаад төсөл ирүүлсэн Хоршоо, ААН, иргэн байхгүй байна.
- Сумын хэмжээнд 1 хоршоо, 2 нийтийн хоол, тусгай зөвшөөрөлтэй 2 ААН, 3 хүнсний дэлгүүр үйл ажиллагаа явуулж байна.
- Хоршоо хөгжүүлэх сангийн орлогын төлөвлөгөө 70,9 хувийн биелэлттэй . Санд одоогийн байдлаар 44 сая төгрөг байна.
- Хоршоо хөгжүүлэх сангийн хяналтын зөвлөл 2 удаа ажилласан. Хоршоо хөгжүүлэх сангийн 2021-2023 оны гүйцэтгэлд санхүүгийн дотоод аудит орж байна.

Орон нутаг хөгжлийн сангийн хэрэгжилт

2022 оны болон 2023 оны 8 сар хүртэл ОНХС-гийн гүйцэтгэлийн үйл ажиллагаанд санхүүгийн дотоод аудит орлоо.

Сумын төвийн гэрэлтүүлэг засварын ажил бүрэн хийгдэж ажлын хэсэг хүлээн авлаа.

Наадмын талбайг өргөтгөх нэмэлт ажил хийх тендерт Дүүрэнзул ХХК шалгарч гэрээ байгуулан ажиллаж байна.




Мэдээллийн илт тод байдал

- Цахим мэдээллийн нийтлэл, түгээлт,
- Цахим болон цахим олон нийтийн сүлжээ


ендоо" сугалааны үйл ажиллагаа зохион байгуулсан бөгөөд бусдаасаа ёндоотой байсан иргэддээ баяр хүргэж сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. 🍀
Ивээн тэтгэгч байгууллагууд: Монгол даатгал, Ард даатгал, Мобиком салбар, "Оорцог-Элгэн" хоршоо, "Чоёо" цэцгийн дэлгүүр



🟢 "Амар тайван амьдралыг бид хамтдаа цогцлооно" Их-Уул баг дээр болсон өдөрлөгийн үеэр 🚗 Соёлтой жолоочид талархал илэрхийллээ. 🍀



Thank You!!
😊



Анхаарал хандуулсанд
баярлалаа